



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/661

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Залуучуудын холбоо төрийн бус байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу тус байгууллагаас 12 дугаар сард зохион байгуулах төлөвлөгөөт ажилд 10,000,000 (арван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Залуучуудын дэд хөтөлбөр” зардалаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ